



**ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ**



ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

(2018 - 2022 он)

УЛААНБААТАР ХОТ

ӨМНӨХ ҮГ

Халдварт өвчинтэй тэмцэх Ази номхон далайн бүсийн стратеги, Олон улсын эрүүл мэндийн дүрэм, Эрүүл мэндийн тухай, Дархлаажуулалтын тухай, Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, Дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай Монгол Улсын хууль, Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого/2017 оны ЗГ-ын 24 тогтоол/, Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр 2017-2020 он, Элэг бүтэн монгол хөтөлбөр, БЗДХ/ХДХВ/ДОХ-оос сэргийлэх болон Эрүүл мэндийн лабораторийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх стратегиудыг хэрэгжүүлэх, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор тус төвийн 2018-2022 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулав.

Хэтийн төлөвлөгөөнд төвийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, зорилго, зорилтуудыг тодорхойлж хэрэгжүүлснээр хүн амын эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт халдварт өвчний учруулж болзошгүй аюул, эрсдлийг бууруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэн, шинжлэх ухаан, мэдээлэлийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжин, олон улсын байгууллага, салбар дундын хамтын ажиллагаагаа уялдуулан зохицуулан ажиллана.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2018-2022 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад хамтран ажилласан Эрүүл мэндийн яаманд талархал илэрхийлье.

Ашигласан материал:

- Олон улсын эрүүл мэндийн дүрэм
- Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030
- Эрүүл мэндийн тухай хууль
- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого 2017 оны ЗГ-ын 24р тогтоол-2017-2021
- Халдварт өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр 2017-2020
- Элэг бүтэн монгол үндэсний хөтөлбөр 2017-2020

ТОВЧЛОЛ

IHR /ОУЭМД/	Олон улсын эрүүл мэндийн дүрэм
APSED /ХӨТАНДБС/	Халдварт өвчинтэй тэмцэх Ази номхон далайн бүсийн стратеги
WHO /ДЭМБ/	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ШУА	Шинжлэх ухааны академи
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
АУХ	Анагаах ухааны хүрээлэн
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
EWAR /ЭСХАХАТ/	Халдварт өвчний эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоо
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар,
ХДХВ/ДОХ	Хүний дархлал хомсдолын вирус, Дархлалын олдмол хомсдол
ОЭДС	Олон эмэнд дасалтай сүрьеэ
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
АЭМГ	Аймгийн эрүүл мэндийн газар
БОЭТ	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв
ТББ	Төрийн бус байгууллага
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Нэг. Халдвар Өвчин Судлалын Үндэсний төвийн танилцуулга

1.1. Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв:

Монгол Улсад Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын Эрүүл Мэндийн Сайдын 2001 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 34 дүгээр тушаалаар Халдвартын клиникийн эмнэлэг, Халдварт өвчин судлалын төв, Сүрьеэгийн үндэсний төв, Сүрьеэгийн клиникийн эмнэлэг зэрэг байгуулагууд нэгдэж Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/-ийг байгуулагдсан байна. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн гүйцэтгэж байсан “Гепатит, томуу, сүрьеэ зэрэг халдварт өвчнөөс сэргийлэх, түүнийг оношлох, эмчлэх шинэ арга” сэдвүүдийг гүйцэтгэгчдийн хамт ХӨСҮТ-д 2001 оны 4 дүгээр сарын 1-ний дотор шилжүүлэхээр шийдвэрлэжээ. ХӨСҮТ-ийг бүтэц зохион байгуулалтын хувьд бүрдүүлсэн эдгээр байгууллагууд нь Монгол Улсын Эрүүл мэндийн салбарт түүхэн үүрэг гүйцэтгэсэн өөр өөрийн баялаг түүхтэй юм.

1.2. Сүрьеэгийн алба:

Монгол улсад сүрьеэтэй тэмцэх алба үүсэж, хөгжсөн түүх бусад оронтой харьцуулахад богино ч шинээр байгуулагдсанаас хойш тун бага хугацаанд сүрьеэтэй тэмцэх ажлыг эрчимтэй явуулж, дэлхийн жишигт хүргэн, 2011 онд ДЭМБ-аас дэвшүүлсэн зорилтыг биелүүлжээ. 1936 онд Төв эмнэлгийн дэргэд 15 ортой сүрьеэгийн тасгийг нээснээр сүрьеэтэй тэмцэх албаны суурь тавигдсан юм. 1943 онд сүрьеэгийн анхны диспансерийг байгуулж, 1946 онд Богд уулын Төр хурахын аманд айргийн сувилал нээснээр сүрьеэтэй өвчтөнд шат дараалсан эмчилгээ хийх боломжтой болжээ.

1950 онд сүрьеэг эсэргүүцэх диспансерийг өргөтгөн, уушги, хүүхэд, ясны сүрьеэгийн кабинетуудтай төв диспансер болгож, Төв эмнэлгийн сүрьеэгийн тасгийг өргөтгөж, мэс засал, ясны сүрьеэгийн тасгийг шинээр нээжээ. 1950-1953 онуудад Ховд, Дорнод, Алтанбулаг, Архангайд сүрьеэгийн диспансерийг нээн ажиллуулжээ. 1953 онд Төв эмнэлгийн сүрьеэгийн тасгийг өргөтгөж сүрьеэг эмчлэх уушгины, ясны, хүүхдийн гэсэн 3 тасагтай, 180 ортой бие даасан эмнэлэг болгожээ. 1994 онд Сүрьеэ, уушгины эмгэг судлалын нэгдсэн төвийг Сүрьеэтэй тэмцэх үндэсний төв болгож, бүтэц зохион байгуулалтыг шинэчилсэн юм.

1.3. Халдварт өвчний тандалт, сэргийлэлтийн алба:

1940 оны 3 дугаар сард бактер шинжилгээний газарт халдвар судлалын тасаг байгуулж халдварт өвчнийг бүртгэж мэдээлэх голомтод арга хэмжээ авах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэх үүргийг хариуцуулжээ.

1942 онд Улаанбаатар хотын Эрүүлийг хамгаалах хэлтсийн дэргэд ариун цэвэр халдвар судлалын тасаг байгуулж, 1948 оноос станц болгосон байна.

1958-1970 онуудад улс, орон нутгийн хэмжээнд ариун цэвэр халдвар судлалын нэгж тусламжийн албадыг нэгтгэн Халдварт өвчин судлалын төвийг байгуулан улс, нийслэлийн хүн амын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг хариуцуулан гүйцэтгэжээ.

“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” Засгийн Газрын 1996 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 153 дугаар тогтоолоор Халдварт өвчин судлалын төв байгуулагдсан байна.

1.4.ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны алба:

Монгол улсад БЗДХ-тай тэмцэх, сэргийлэх ажил 1925 оноос эхэлж, Арьс өнгөний өвчинтэй тэмцэх салбар нэртэйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн. 1987 онд Сайд нарын зөвлөлийн 171-р тогтоолоор ЭАХНС-ын институтийн харьяанд ДОХ-ын лавлагаа төвийг байгуулсан байна.

1994 онд Засгийн газрын 153 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн засаг даргын хамтарсан тушаалаар АӨЭСТ-ийн бэлгийн замын халдварын хэсэгтэй нэгтгэн ДОХ/БЗДХ-ын лавлагаа төв болгон үйл ажиллагааг нь өргөжүүлсэн байна.

Одоо тус алба нь ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны алба нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Уг алба нь БЗДХ-ын эмчилгээ тусламж үйлчилгээ, ХДХВ/ДОХ-ын эмчилгээ тусламж үйлчилгээ гэсэн 2 тасагтайгаар 23 их эмчтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

1.5.Халдвартын эмнэлэг:

Халдвартын эмнэлэг нь 1947 оны 6 дугаар сарын 20-нд Улсын төв эмнэлгээс салбарлан 200 ортой, үндсэн 5 тасагтай, 86 орон тоотойгоор Богд уулын аман дахь Зайсан толгойн дэргэдэх Зөвлөлийн цэргийн эмнэлгийн байранд байгуулагджээ.

Тус эмнэлэг нь 20 жилийн (1947-1967 он) дотор 400 ортой 7 тасагтай клиникийн болон бактериологи, биохимийн лаборатори, угаалга ариутгал, рентген, электрокардиограф, мэс засал, эмгэг анатомын тасагтай, архаг цусан суулгатай хүүхдийн 60 ортой ясли, зарим халдварт өвчний кабинет, номын сан, радио узел бүхий эмнэлэг, үйлчилгээний 22 салбартай Халдвартын төв эмнэлэг болсон.

1981 онд СНЗ-ийн 329 дүгээр тогтоолоор Халдвартын төв эмнэлэгт 200 ортой хүүхдийн халдварт өвчнийг эмчлэх больницыг нэгтгэн 725 ортой, 12 тасагтай, 8 туслах тасаг салбартай, 700 гаруй эмч, ажилчидтай, Халдварт өвчнийг анагаах клиникийн эмнэлэг болж өргөжин үйл ажиллагаагаа явуулж иржээ.

1.6.Халдварт өвчин судлалын сектор:

Халдварт өвчин судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулдаг анхны байгууллага нь 1961 онд байгуулагдсан ШУА-ын харьяа Анагаах Ухааны хүрээлэнгийн халдвар нян судлалын сектор байв. Хожим нь 1968 онд тус хүрээлэн нь ЭМЯ-ны харьяанд шилжсэн бөгөөд, 1985 онд АУХ-ийн Халдвар-эпидемиологийн сектор нь тэр үеийн ЭАХНСУИ-ийн Вирус судлалын лабораторитой нэгдэн Эрдэм шинжилгээний салбар, 1994 онд ЭАХНСҮТ-ийн Вируст гепатитын сектор, 1997 НЭМХ-ийн Халдварт өвчний судлагаа шинжилгээний төв болон өөрчлөгдөн зохион байгуулагдаж халдварт өвчин судлалын чиглэлээр олон арван судалгааны ажлуудыг явуулж иржээ.

1.7.Нэгдсэн лабораторийн алба

Халдварт өвчнийг оношлох, эмчлэх ажлын нэг гол тулгуур нөхцөл нь лабораторийн оношлогоо байдаг ба ХӨСҮТ-д Нэгдсэн лабораторийн албанд багтаж буй лабораторийн түүхэн замнал нь 1929 онд Зөвлөлт Холбоот Улсын тусламжтайгаар төв больницийн бүтцэд байгуулагдсан клиникийн бактер судлалын лаборатори, 1960 онд байгуулагдсан, ЭАХНСУИ-ийн вирус судлалын лаборатори, 1947 онд

байгуулагдсан халдвартын эмнэлгийн клиник болон бактериологи, биохимийн лаборатори үүсэж хөгжсөн түүхтэй холбоотой.

Улмаар эдгээр лабораториуд нь оношлогооны чадамж, хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн хувьд улам бэхжиж, 2007 онд микробиологийн лавлагаа лаборатори болон зохион байгуулагдсан.

Хоёр. Өнөөгийн нөхцөл байдал

2.1 Дотоод орчны шинжилгээ

2.1.1 Төвийн тодорхойлолт:

Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв нь халдварт өвчний тандалт сэргийлэлт, оношлогоо, эмчилгээ, эрдэм шинжилгээ, сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулах, хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх эрх, үүрэг бүхий тусгай мэргэжлийн төв байгууллага мөн.

2.1.2 Төсөв, санхүүжилт

Төвийн санхүүжилт нь улсын төвлөрсөн төсөв, эрүүл мэндийн даатгал, үндсэн ба туслах үйлажиллагааны орлого, халдварт өвчний чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн санхүүжилт болон бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

2017 оны байдлаар 17,49 тэрбум төгрөгийн санхүүжилттэй үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 93,9 % нь улсын төвлөрсөн төсвөөс, 5,1 % нь эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,0 % нь үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжиж байна.

2.1.3 Дэд бүтэц

Тус төв нь 9 га талбайг эзэлсэн 23 барилга байгууламжтай, 19.7 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөтэй.

1.1 2.1.4 Хүний нөөцийн бүтэц зохион байгуулалт

Төв нь 16 алба, 3 нэгж, 2 клиник, 42 тасагтай.

Хүний нөөцийн бүтэц, зохион байгуулалтын талаар:

➤ **Ерөнхий захирал**

➤ **Дэд захирал**

1. Халдварт өвчний тандалт сэргийлэлт эрхэлсэн дэд захирал
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд захирал
3. Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал

➤ **Албадууд:**

1. Санхүү бүртгэлийн алба
2. Хүний нөөцийн алба
3. Чанарын алба
4. Хангамж үйлчилгээ, инженер технологийн алба
5. Эмнэлгийн мэргэжилтний сургалт хөгжлийн алба
6. Дархлаажуулалтын алба
7. Халдварт өвчний тандалт судалгааны алба
8. Нэгдсэн лабораторийн алба
9. ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны алба
10. Сүрьеэгийн тандалт судалгааны алба
11. Талбарын тархвар судлалын алба
12. Эм зүйн алба
13. Сувилахуйн алба
14. Мэдээлэл технологийн алба
15. Соёл үйлчилгээний алба
16. Инженер техникийн алба

➤ **Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгж, тасгууд:**

1. Шуурхай удирдлагын нэгж
2. Амьсгал томуугийн үндэсний нэгж
3. Эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээний нэгж
4. Эмнэлгээс шалтгаалах халдвартай тэмцэх сэргийлэх тасаг
5. Хепатит, гэдэсний халдвартай тэмцэх сэргийлэх тасаг
6. Зооноз бруцеллёзын халдвартай тэмцэх сэргийлэх тасаг
7. Нян судлалын лабораторийн тасаг
8. Клиник биохимийн лабораторийн тасаг
9. Вирус судлалын лабораторийн тасаг
10. Бэлгийн замаар дамжих халдварын лабораторийн тасаг
11. Вируст гепатит, энтеровирусын лабораторийн тасаг
12. Шимэгч судлалын лабораторийн тасаг
13. ДОХ/БЗДХ-ын ТСАлбаны үзлэг хяналтын тасаг
14. ДОХ/БЗДХ-ын ТСАлбаны тандалт судалгааны тасаг

15. СТСАлбаны үзлэг хяналтын тасаг
16. СТСАлбаны микобактерийн лавлах лабораторийн тасаг
17. Дархлаажуулалтын албаны тандалт судалгаа, сургалт сурталчилгааны тасаг
18. Дархлаажуулалтын албаны вакцин биобэлдмэл, хангалтын тасаг

➤ **Туслах үйлчилгээний тасгууд:**

1. Клиник статистикийн тасаг
2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасаг
3. Амбулаторийн тасаг
4. Онош зүйн тасаг
5. Эмнэлгийн гал тогооны тасаг
6. Ариутгал халдваргүйтгэлийн тасаг
7. Эд эсийн лаборатори

➤ **Халдвартын клиникийн тасгууд**

1. Яаралтай тусламжийн тасаг
2. Өдрийн эмчилгээний тасаг
3. Халдвартын клиникийн сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тасаг
4. Агаар дуслын халдварын тасаг
5. Зооноз бруцеллёзын тасаг
6. Гэдэсний халдварын тасаг
7. Насанд хүрэгчдийн цочмог гепатитын эрэгтэй тасаг
8. Насанд хүрэгчдийн цочмог гепатитын эмэгтэй тасаг
9. Шинэ болон дахин сэргэж буй халдварын тасаг
10. Элэгний клиникийн тасаг

➤ **Сүрьеэгийн клиникийн тасгууд:**

1. Сүрьеэгийн хүлээн авах тасаг
2. Сүрьеэгийн клиникийн сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тасаг
3. Хүүхдийн уушгины тасаг
4. Мэс заслын тасаг
5. Уушгины 1-р тасаг
6. Уушгины 2-р тасаг
7. Олон эмэнд дасалтай сүрьеэгийн 1-р тасаг
8. Олон эмэнд дасалтай сүрьеэгийн 2-р тасаг

Албан тушаалаар:


- Төрийн үйлчилгээний удирдах албан хаагч - 4 буюу 0,5 %
- Төрийн үйлчилгээний эмнэлгийн дээд мэргэжлийн албан хаагч- 210 буюу 28,1%
- Төрийн үйлчилгээний бусад дээд мэргэжлийн ажилтан - 44 буюу 5.9%
- Төрийн үйлчилгээний сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтэн – 278 буюу 37.2%
- Төрийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан хаагч -212 буюу 28,4%

Хүний нөөцийн чадавх:

Хүний нөөцийн чадавхийн хувьд тус төвд Анагаахын шинжлэх ухааны профессор-2, дэд профессор -1 АШУ-,доктор 15, биологийн шинжлэх ухааны доктор 1, клиникийн профессор 41, магистр 63, мэргэжлийн зөвлөх зэрэгтэй эмч 3, мэргэжлийн тэргүүлэх зэрэгтэй эмч 56, ахлах зэрэгтэй эмч 64, тэргүүлэх зэрэгтэй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 28, ахлах зэрэгтэй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 99 ажиллаж байна.

2.1.5. Гадаад харилцаа

Төв нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага “JICA”, Дэлхийн Зөн, АНУ-ын “Өвчний Хяналт Сэргийлэлтийн Төв” /“CDC”/ зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахын зэрэгцээ, АНУ-ын Алабамын Их сургууль, Флоридагийн Их Сургууль, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын “Сүрьеэтэй тэмцэх газар” болон “Хелиос эмнэлэг”, Япон Улсын Токио хотын “Анагаах ухааны их сургууль”, Канагава мужийн “Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн”, Австрийн “Ийлдэс судлалын лавлагаа лаборатори”, Хонг Конгдахь “Улаан бурханы лавлагаа лаборатори”, “Нийгмийн Эрүүл Мэндийн Төв лаборатори”, Бүгд найрамдах Солонгос Улсын “Өвчний хяналт сэргийлэлтийн төв”, Тайван Улсын “Үндэсний их сургуулийн эмнэлэг”, “Халдварт өвчин судлалын институт”, Сингапурын “Нан янг”-ийн Их сургууль, БНХАУ-ын Өвчний хяналт сэргийлэлтийн төв, БНХАУ ын ӨМӨЗО-ы “Сүрьеэтэй тэмцэх төв”, Хөх Хотын “Элэгний 2-р эмнэлэг”, ОХУ-ын Эрхүү хотын “Халдварт өвчний тархвар судлалын төв”, Кемеров мужийн эрүүл мэндийн байгууллага, Япон улсын Дэлхийн эрүүл мэндийн АУ-ны төв, ДОХ-ын эмнэлзүйн төв зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж үйл ажиллагаагаа өргөжүүлж байна.



2.1.6 Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх талаар гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж хэрэгжүүлэх.
- Олон Улсын Эрүүл Мэндийн Дүрэм Шинэ болон сэргэж буй халдвартай тэмцэх Ази номхон далайн бүсийн стратегийг Эрүүл мэндийн яамны удирдлага дор хэрэгжүүлэх.
- Халдварт өвчний дэгдэлтийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах тандалтын тогтолцоог бүрдүүлж Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх.
- Эрт сэрэмжлүүлэг хариу арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шуурхайн удирдлагын нэгжээр дамжуулан аймаг орон нутгийн болон анхан шатны тандалтын нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.
- Халдварт өвчнийг оношлох, эмчлэх, нөхөн сэргээх тусламж үйлчилгээг зохион байгуулж хэрэгжүүлэх.
- Халдварт өвчний тандалт, оношлогоо, эмчилгээний стандарт, удирдамж, аргачлал боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, арга зүйгээр хангах.
- Улсын хэмжээний халдварт өвчний өвчлөл, хам шинж, сэжигтэй тохиолдлын мэдээнд 7 хоног, сар, улирал, жилээр үнэлгээ, дүгнэлт, өгч шаардлагатай тохиолдолд хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх.
- Хүн амд чиглэсэн халдварт өвчний мэдээлэл, сургалт, суртачилгааны ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах.
- Халдварт өвчний тандалт сэргийлэлт, оношлогоо эмчилгээ, эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр Олон Улсын байгууллага, гадаад орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, төсөл, хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх.
- Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүний нөөцийг чадавхижуулах.

2.1.7.Халдварт өвчний тандалт судалгаа

- Нийгмийн эрүүл мэндийн суурь тогтолцоо, салбар хоорондын хамтын ажиллагаа, харилцаа холбоо, зохицуулалтыг сайжруулах замаар нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд бэлэн байх, илрүүлэх, хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх;
- Улсын хэмжээнд халдварт өвчний дэгдэлтийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоог бэхжүүлэх, халдварт өвчний тандалт сэргийлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах;
- Шуурхай удирдлага, Тохиолдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, үйл явдлын эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн түвшинд тохирсон хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах;
- Эрүүл мэндийн байгууллагын халдвар хяналтын тогтолцоог бэхжүүлж, тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллах;
- Халдварт өвчний хэтийн төлөв хандлагыг тодорхойлох;
- Халдварт өвчин судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх;
- Халдварт өвчний мэргэжлийн сургалт явуулах;

- Хүн амд зориулсан сургалт сурталчилгааг зохион байгуулах;
- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэхэд нийслэл, орон нутгийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах;
- Томуу, томуу төст өвчний лабораторид түшиглэсэн тандалт, хяналтын сүлжээг нэвтрүүлж, томуугийн дарамтын судалгааг гаргах;

Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалт судалгаа

- Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалтын тогтолцоог боловсронгуй болгох, өвчлөл, эндэгдлийг эрс бууруулах, устгах нөхцлийг бүрдүүлэх.

- Дархлаажуулалт бүхий халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэхэд нийслэл, орон нутгийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах.

- Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалт, сэргийлэлт, дархлаажуулах чиглэлээр хууль, эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулах, шинэчлэх.

- Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалт судалгаа хийх, хэтийн төлөв хандлагыг тодорхойлох.

- Дархлаажуулалт бүхий халдварт өвчний дэгдэлтээс сэргийлэх, голомтод шуурхай хариу арга хэмжээг удирдан зохион байгуулах.

- Вакцины захиалга хийж, чанартай, баталгаатай вакцинаар тасралтгүй хангах

- Дархлаажуулалт бүхий халдварт өвчин судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх.

- Дархлаажуулалт бүхий халдварт өвчний мэргэжлийн сургалт явуулах.

- Хүн амд зориулсан сургалт сурталчилгааг зохион байгуулах.

2.1.8. Сүрьеэ өвчний тандалт судалгаа

1. “Сүрьеэгээс сэргийлэх, хянах сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулж, үндэсний лавлагаа тусламж үйлчилгээ үзүүлнэ.
2. Сүрьеэгийн тандалт, оношилгоо, эмчилгээ, урьчилан сэргийлэх стандарт, заавар, удирдамжийг боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавьж, эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
3. Сүрьеэгийн өвчлөл, тархалт, нас баралт, эмчилгээний үр дүнг тандан, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг гүйцэтгэж, нотолгоонд суурилсан арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.
4. Сүрьеэгийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж, халдвар хяналтын хэрэгсэл, эм, урвалж бодис, оношлуур захиалах, хүлээн авах, хадгалах, хуваарилах, зарцуулалтанд хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулна.
5. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах, чадавхижуулахад мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлнэ.
6. Олон улсын лавлагаа лабораторийн гадаад чанарын хяналтын үнэлгээнд хамрагдах, сүрьеэгийн сүлжээний 38 лабораторийг гадаад чанарын

үнэлгээнд хамруулж чанарын хяналтын гүйцэтгэлийг эргэн мэдээлж, хариу арга хэмжээ авах.

7. Ухуулга нөлөөлөл, олон нийтийн оролцооны байдалд үнэлгээ хийж, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт ухуулан таниулна.
8. Хүн амын дунд сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулна.
9. Шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагч, хэвлэл мэдээллийн төлөөлөл, ТББ, хувийн хэвшил, мэргэжлийн холбоо, өвчтөний дэмжих бүлэг, шашны төлөөллийн дунд яриа, хэлэлцэл явуулах, зөвшилцлийг замаар олон нийт, бусад оролцогч талуудын харилцааг бэхжүүлнэ.

2.1.9.БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тандалт судалгаа

ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны алба нь:

ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны алба нь Монгол улсын ХДХВ/ДОХ-той тэмцэх сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, ХДХВ/ДОХ/БЗДХ-тай холбоотой тушаал зааврыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангаж, лавлагаа төвийн тусламж үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй.

ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны алба нь улс, хотын хэмжээнд:

- Үндэсний хэмжээнд БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх хөтөлбөрүүд, тогтоол, тушаал, шийдвэрүүдийг хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
- ХДХВ/ДОХ/БЗДХ-ын оношилогоо эмчилгээний үндэсний стандарт , арга аргачлал, урьдчилан сэргийлэх чиглэлээр заавар, зөвлөмж, боловсруулж батлуулах.
- БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тархалт, өвчлөл, нас баралтыг тандан судлах нэгтгэн дүгнэх, эргэн мэдээлэх.
- ХДХВ/ДОХ/БЗДХ-ын талаар тулгамдсан асуудлуудыг удирдах дээд байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх.
- БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тусламж үйлчилгээний чиглэлээр БЗДХ-ын эмч, холбогдох бусад мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт сургалт, уулзалт, семинар зохион байгуулах.
- Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ыг мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.
- БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл сургалт сурталчилгааны материал боловсруулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулах.
- БЗДХ/ХДХВ/ДОХ-ын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд илтгэл, өгүүлэл хэлэлцүүлэх.

2.1.10.Лабораторийн тусламж үйлчилгээ

- Үйлчлүүлэгчид чанартай, найдвартай, сэтгэл ханамжтай лабораторийн тусламж, үйлчилгээ үзүүлэх.
- Нян судлал, вирус судлал, шимэгч судлал, ийлдэс судлалын чиглэлээр улсын хэмжээнд лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэх.
- Дээрх лабораторийн чиглэлээр 1, 2-р шатлалын лабораториудыг мэргэжил арга зүйгээр хангах.
- Лабораторийн тулгамдсан асуудлуудаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах.
- Бичил амь судлалын чиглэлээр мэргэжил олгох болон дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах.
- Бичил амь судлалын чанарын гадаад, дотоод хяналтыг явуулах.
- Халдварт өвчний голомтонд үүсгэгч илрүүлэх, хариу арга хэмжээ авахад оролцох.
- Олон улсын байгууллагатай холбоотой ажиллаж, бичил амь судлалын лабораторийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, шинэ технологи арга аргачлал нэвтрүүлэх.

2.1.11.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

- ХӨСҮТ нийт 554 ортой, үүнээс клиникт 330, Сүрьеэгийн клиникт 200 ор, өдрийн эмчилгээний 20 ор, хөнгөвчлөх эмчилгээний 4 ортой тус тус ажиллаж байна. Нийт эмчилгээний 18 тасагтай ажиллаж байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:
- Халдварт өвчний чиглэлээр үндэсний хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах.
- Цочмог халдварт өвчин болон шинэ, дахин сэргэж буй халдвар, сүрьеэ өвчний оношлогоо, эмчилгээ, сувилахуйн стандарт, удирдамжийг шинэчлэн боловсруулах.
- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчний болзошгүй цар тахлын үед эмнэлгийн тусламж үйлчилгээний шуурхай, тасралтгүй бэлэн байдлыг ханган ажиллах.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хүний нөөцийг хөгжүүлэх.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар үр дүнг тасралтгүй дээшлүүлж, иргэдэд нээлттэй мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг ханган ажиллах.
- Халдвар хяналтын үйл ажиллагааг бэхжүүлж, эмнэлгээс шалтгаалсан халдвараас сэргийлэх.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд цахим мэдээлэл, программ хангамжийг нэвтрүүлэх.
- Зайлшгүй шаардлагатай эм урвалж, эмнэлгийн хэрэгсэлээр тасралтгүй ханган ажиллах ба үйлчлүүлэгчдэд эмийн зөв зохистой хэрэглээний талаарх мэдээллийг өгч байх.

2.2 Гадаад орчны шинжилгээ

2.2.1. Халдварт өвчний байдал

Улсын хэмжээнд 2017 онд 28 төрлийн 44 300 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн ба 10.000 хүн амд 144.9 тохиолдол байгаа нь өмнөх оны мөн үеэс 82.9 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Нийт бүртгэгдсэн халдварт өвчний дотор амьсгалын замын (35.7%), бэлгийн замын (34.7%), гэдэсний халдварт өвчин (23.8%) дийлэнх хувийг эзэлж байна. 2016 онтой харьцуулахад бэлгийн замын халдвар 13.2%-иар, гэдэсний халдвар 10.8%-иар нэмэгдсэн, амьсгалын замын халдвар 26.3%-иар буурсан байна.

Улсын хэмжээнд 2017 онд бүртгэгдсэн нийт халдварт өвчин (10.000 хүн амд) Дорнод (381.2), Сүхбаатар (216.1) аймгууд болон Улаанбаатар хотод (190.2) нэмэгдсэн ба улсын дундажтай харьцуулахад (144.9) өндөр, 2016 онтой харьцуулахад Дорнод аймагт 44.1 толхиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна

2.2.3. SWOT шинжилгээ:

ДАВУУ ТАЛ /STRENGTHS/	СУЛ ТАЛ /WEAKNESSES/
<ol style="list-style-type: none"> 1. Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх бодлого, удирдлага, мэргэжил арга зүй, сургалт судалгаа, эрдэм шинжилгээний үндэсний лавлагаа төв 2. Бүртгэл мэдээллийн сан сүлжээний эх үүсвэр тавигдсан 3. Халдварт өвчний голомтод шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх мэргэжлийн багтай 4. Халдварт өвчнийг тандах, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх мэргэжил арга зүйгээр хангах мэргэшсэн эмч мэргэжилтэнтэй 5. Хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах тогтолцоо 6. Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны лавлагаа төв 7. Стандартад нийцсэн барилга байгууламжтай 	<ol style="list-style-type: none"> 1. Аймаг, нийслэлийн түвшинд халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэхэд, орон нутгийн шийдвэр гаргагчдын мэдлэг сул 2. Халдварт өвчний бүртгэл мэдээлэл, лабораторид суурилсан тандалтын тогтолцооны чадавхи сул 3. Хүний нөөцийн хөгжлийн зөв бодлого хангалтгүй (MNS:6330) 4. Халдварт өвчний оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанар, эрүүл мэндийн үр дүн, эдийн засгийн үр ашгийг тооцоолдоггүй, шаардлагатай багаж тоног төхөөрөмж оношлуур хангалтгүй 5. Техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалт, хангалтын бодлогогүй, инженерийн шугам сүлжээ хэт хуучирсан
БОЛОМЖ /OPPORTUNITIES/	АЮУЛ ЗАНАЛ /THREATS/
<ol style="list-style-type: none"> 1. ОУ-ын эрүүл мэндийн дүрэм /2005 он/ 2. Төрийн байгууллагуудад бүтээгдэхүүн, үр дүнд суурилсан удирдлагын шинэ тогтолцоо хэрэгжиж эхэлсэн 3. Төрийн болон төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой 4. Нэг хүнд ногдох ДНБ, улсын төсөвт эзлэх эрүүл мэндийн 	<ol style="list-style-type: none"> 1. Улс төрийн байдлаас хамаарч мэргэжлийн байгууллагын удирдлага, бүтэц зохион байгуулалт алдагдах, үйл ажиллагаа доголдох магадлалтай 2. Байгаль экологийн өөрчлөлт, шинэ болон дахин сэргэж буй халдварууд ОУ-ын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчнүүд орж ирэх өндөр эрсдэлтэй 3. Олон улсын терроризм 4. Нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал

салбарын санхүүжилт нэмэгдэж байна 5. Техник технологийн хурдацтай хөгжил 6. Орчин үеийн био-аюулгүй ажиллагааны 3-р зэрэглэлийн лаборатори	
---	--

Гурав. Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх үйл ажиллагааны тулгамдсан асуудал

3.1 Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааны удирдлага төлөвлөлт, боловсронгуй бус.

3.2 Орон нутгийн түвшинд халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх бүтэц, хүний нөөц дутмаг

3.3 Үндэсний хэмжээнд халдварт өвчний лабораторийн сүлжээ бэхжээгүй, орон нутгийн лабораторийн оношлогооны чадавхи хангалтгүй.

3.4 Ретровирусийн эсрэг эмчилгээний эмийн дасал тодорхойлох лабораторийн тоног төхөөрөмж хүний нөөц бүрдээгүй. БЗДХ-ын тандалтын тогтолцоо сул, хүний нөөц (халдвар судлаач, сэтгэлзүйч г.м)хангалтгүй, ийлдэс, нян судлалын лабораторийн чадавхи сул.

3.5 Сүрьеэгийн тархалт өндөр,

3.6 Дархлаажуулалт бүхий халдварт өвчний асуудал

3.7 Халдварт өвчнийг оношлох, эмчлэх үйл ажиллагааны чанар, хүртээмж хангалтгүй, удирдлага төлөвлөлт боловсронгуй бус.

3.8 Халдварт өвчнөөс сэргийлэх талаархи хүн амын мэдлэг, хандлага, үүрэг хариуцлага хангалттай бус.

3.9 Сургууль хүүхдийн байгууллагын ачаалал хэт их, норм нормативийг барьдаггүй

3.10 Орчны ариун цэвэр эрүүл ахуйн нөхцөл хангалтгүй, хөрсний бохирдол, хог хаягдал ихэссэн

Дөрөв. Төвийн стратеги

ХӨСҮТ-ийн 2018-2022 оны стратегийн зорилго, зорилтыг хангах стратегийн хувилбар, баримтлах үндсэн 4 чиглэлийг TOWS матрицын аргыг ашиглан тодорхойлов.

4.1. Үндэсний төвийн 2018-2022 онд баримтлах стратегийн чиглэл

- 4.1.1 Олон Улсын Эрүүл Мэндийн Дүрмийн шаардлагын дагуу үндэсний чадавхи, халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, бэхжүүлэх, халдварт өвчнийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах тандалтын тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх;
- 4.1.2 Үр дүнд суурилсан удирдлага төлөвлөлтийн тогтолцоо, гадаад дотоод хамтын ажиллагааг бүхийл талаар өргөжүүлэн, хөгжүүлэх, Шинжлэх Ухаан технологийн ололтыг хурдацтай нэвтрүүлэх замаар халдварт өвчний удирдлага төлөвлөлт, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанар, үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх;
- 4.1.3 Халдварт өвчний бодлого стратеги, төвийн алсын хараа эрхэм зорилгыг хэрэгжүүлэх оновчтой, тогтвортой бүтэц, зохион байгуулалт, өндөр чадвартай мэргэшсэн удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй байх;
- 4.1.4 Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлж, болзошгүй аюулыг даван туулах бэлэн байдлыг хангах, нийгмийн эмзэг, ядуу бүлэгт чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх;

4.2. Төвийн алсын хараа

Олон улсын эрүүл мэндийн дүрэм, халдварт өвчинтэй тэмцэх Ази номхон далайн бүсийн стратегийн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, шинжлэх ухаан технологийн дэвшил, салбар хоорондийн хамтын ажиллагааг, хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжигч тэргүүлэгч байгууллага байх.

4.3. Эрхэм зорилго

Үйлчлүүлэгч, эмнэлгийн мэргэжилтнээ дээдэлсэн мэргэжлийн шилдэг байгууллага байж, чанартай, аюулгүй тусламж үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх.

4.4. Эрхэмлэх үнэт зүйлс

1. Урьдчилан сэргийлэлт - эрт илрүүлэлт - оношлогоо - эмчилгээ - хяналт
2. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, тандалт, судалгаа
3. Харилцаа хандлаг, ёс зүйн соёл
4. Ур чадвар бүхий мэргэшсэн баг
5. Сэтгэлд шингэсэн үйлчилгээ
6. Дэвшилтэт шийдэл

4.5. Төвийн 2018-2022 оны стратегийн зорилго

- 4.5.1 Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх үйл ажиллагааны удирдлага төлөвлөлтийг боловсронгуй болгох,
- 4.5.2 Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх, Шуурхай удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, бэхжүүлэх
- 4.5.3 Үндэсний хэмжээнд халдварт өвчний лабораторийн сүлжээ бий болгож, лабораторийн оношлогооны чадавхийг нэмэгдүүлэх,

- 4.5.4 БЗДХ, ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн цогц, чанартай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, халдварын тархалтыг бууруулах
- 4.5.5 Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалтыг эрчимжүүлэх, дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгддэг халдварт өвчний тохиолдол эндэгдлийг бууруулах, хяналтад авах, устгах нөхцлийг бүрдүүлэх
- 4.5.6 Сүрьеэгийн илрүүлэлт, оношлогоо, эмчилгээнд шинэлэг аргыг нэвтрүүлж, салбар хоорондын олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг цогц байдлаар үзүүлэх,
- 4.5.7 Хепатитийн С /D вирус халдварыг эрт илрүүлэх, оношилох, эмчлэх хянах, түүний хүндрэл эндэгдлийг бууруулах.

4.6.Төвийн стратегийн зорилтууд

4.6.1 Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх үйл ажиллагааны удирдлага, төлөвлөлтийг боловсронгуй болгох зорилгын хүрээнд:

- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үндэсний бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгох,
- Тусламж үйлчилгээний чанар, хүртээмжтэй нягт уялдуулан санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх,
- Улсын хэмжээнд цахим эмнэлгийн сүлжээ, алсын зайн удирдлага арга зүйг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх
- Багаар хамтран ажиллах
- Нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгаа дэвшилтэд технологийг Эмчилгээ оношилгоонд нэвтрүүлэх
- **CDC ажлын хэсэг** судалгааны багтай хамтран ажиллах
- Бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх

4.6.2 ОУЭМД-ийн шаардлагад нийцүүлэн шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах өнөөгийн тогтолцоог бэхжүүлэх зорилгын хүрээнд:

- Аймаг, нийслэлийн түвшинд халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох,
- Эрүүл мэндийн байгууллагын халдвар хяналтын бодлого, тогтолцоог бэхжүүлэх,
- Вируст гепатит өвчнийг хяналтанд авах, Вируст гепатиттай тэмцэх, сэргийлэх үндэсний дэд хөтөлбөр хэрэгжүүлэх,
- Гэдэсний халдвараас сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах өнөөгийн тогтолцоог бэхжүүлэх,
- Зоонозын халдвараас сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах өнөөгийн тогтолцоог бэхжүүлэх.

4.6.3 Үндэсний хэмжээнд халдварт өвчний лабораторийн сүлжээ бий болгож, лабораторийн оношлогооны чадавхийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд:

- Шинэ болон сэргэж байгаа халдварт өвчний үед лабораторийн халдварын эрсдлийг бууруулах,
- Микробиологийн лавлагаа лабораторийг бэхжүүлэх,
- Халдварт өвчний лабораторийн сүлжээ байгуулах нөхцөл бүрдүүлэх,
- Чанарын хяналтын баримт бичгийг боловсруулж, гадаад хяналтыг өргөжүүлэх, дотоод хяналтыг тогтмолжуулах.

4.6.4 БЗДХ, ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн цогц, чанартай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, халдварын тархалтыг бууруулах зорилгын хүрээнд:

- БЗДХ/ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагааг чанаржуулж өргөжүүлэх, хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох
- БЗДХ, ХДХВ/ДОХ-ын нууцлал, хамгаалалт бүхий бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, төр, төрийн бус болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулах
- БЗДХ, ХДХВ/ДОХ-ын эмчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуурын хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор санхүүжилтийг нэмэгдүүлэх.
- БЗДХ, ХДХВ/ДОХ-ын чиглэлээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтний нөөцийг нэмэгдүүлэн сургалтад хамруулах

4.6.5 Сүрьеэгийн илрүүлэлт, оношлогоо, эмчилгээнд шинэлэг аргыг нэвтрүүлж, салбар хоорондын олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг цогц байдлаар үзүүлэх зорилтын хүрээнд:

- Эрсдэлт бүлгийн хүн амын дунд хийж байгаа сүрьеэг илрүүлэх идэвхтэй үзлэгийг тогтмолжуулах
- Сүрьеэгийн оношилгоо, эмчилгээнд шинэ, техник технологи нэвтрүүлэх
- Сүрьеэ өвчний оношилгоо, эмчилгээг чанарын шаардлага хангасан урвалж, бодис оношлуураар тасралтгүй хангах
- Сүрьеэгийн чиглэлээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч, мэргэжилтэн, хүний нөөцийг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
- Сүрьеэгийн тандалтын тогтолцоог бэхжүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх
- Сүрьеэгийн өвчлөлийг бууруулах чиглэлээр үндэсний болон орон нутгийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт зориулсан сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах
- Үйлчлүүлэгчдэд нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагыг татан оролцуулах

- Олон нийтэд суурилсан үйл ажиллагааг өргөжүүлэх замаар сүрьеэгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх
- Эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт, хяналтыг сайжруулан үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх
- Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, зөв мэдлэг хандлага, дадал төлөвшүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх

4.6.6 Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалтыг эрчимжүүлэх, дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгддэг халдварт өвчний тохиолдол эндэгдлийг бууруулах, хяналтад авах, устгах нөхцлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд:

- Дархлаажуулалтын хамралтын цахим бүртгэлийг нэвтрүүлж, хүн амын дархлал тогтоцын түвшинг тогтоох, товлолын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх замаар дархлаажуулалт бүхий халдварт өвчний өвчлөл, эндэгдлийг бууруулах,
- Халдварт саа өвчнийг устгасан байдлаа хадгалах,
- Улаанбурхан, улаанууд өвчний тандалт, хяналтыг сайжруулах, улаанбурхан өвчин бусад улс орноос зөөвөрлөгдөн орж ирэхээс сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах,
- Дархлаажуулалтын үйл ажиллагааг бүхий л шатанд бэхжүүлж, хүний нөөцийн чадавхийг сайжруулж, аюулгүй, чанартай вакцинаар хүн амыг дархлаажуулах, эрүүл мэндийн бусад салбарын хөтөлбөртэй уялдуулах
- Дархлаажуулалтанд шинэ вакциныг нэвтрүүлэх.

4.6.7 Халдварт өвчнийг оношлох, эмчлэх үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах, удирдлага төлөвлөлтийг боловсронгуй болгох зорилгын хүрээнд:

- Парентераль замаар дамжин халдварладаг вируст гепатит өвчний тусламж үйлчилгээг өргөжүүлэх, чанаржуулах,
- Клиникийн эм зүйн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх,
- Эмнэлгийн халдвар хяналтын тогтолцоог бэхжүүлэх,
- Халдварт өвчний сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, соёл, сувилгаа асаргааны үр дүнг дээшлүүлэх,
- Тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, шаардлагатай эмчилгээг цаг алдалгүй үзүүлж, нас баралтыг бууруулах.

4.6.8. Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажлыг өргөжүүлэн хөгжүүлж, түүний практик үр өгөөжийг дээшлүүлэх зорилгын хүрээнд

- Эрдэм шинжилгээний салбарын удирдлага, зохион байгуулалт, чадавхийг сайжруулах,
- Мэргэжлийн сургалтыг чанартай үр өгөөжтэй зохион байгуулах

4.6.9 Байгууллагийн ил тод нээлттэй хагас бие даасан тогтолцоог бэхжүүлэх

4.6.10 Эрүүл мэндийн бодлоготой уялдсан хүний нөөцийн хөгжлийн зураглал, менежментийг нэвтрүүлэх

4.6.11 Төвийн мэдээлэл технологийн хөгжлийг Монгол улсад мөрдөгдөж буй хуулийн хүрээнд Засгийн газрын бодлого, чиглэлд нийцүүлэн технологийг тохирсон, зөв шийдлээр хөгжүүлэхэд оршино.

4.6.12 Төлбөрт тусламж үйлчилгээнд оновчтой механизмыг нэвтрүүлж, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн ажиллах

Тав. Хэтийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Хэтийн төлөвлөгөө, Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх Үндэсний хөтөлбөрийн шалгуур, үзүүлэлт хүрэх түвшинтэй ижил байна.

Шалгуур үзүүлэлт:

	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		2017 оны үр дүн		Хүрэх үр дүн	
			он	үзүүлэлт	он	үзүүлэлт	он	үзүүлэлт
1	Сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол /100.000 хүн амд/	Түвшин	2015	144	2017	136.6	2020	158.9
2	Сүрьеэгийн нас баралт /100.000 хүн амд/	Түвшин	2015	8.5	2017	7.1	2020	6.5

Зургаа. Хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөөц, удирдлага, зохион байгуулалт.

6.1 Төвийг ЭМС-ын тушаалаар томилогдсон Ерөнхий захирал удирдана. Үндэсний төвийн эрх барих дээд байгууллага нь “Удирдлагын зөвлөл” байна. Үндэсний төвийн үндсэн нэгжид алба, клиникууд; алба, клиникийн үндсэн нэгжид тасгууд ажиллах бөгөөд тэдгээр нь өөрсдийн хүлээсэн үүргийн дагуу ажлын гүйцэтгэл, үр дүн, үйл ажиллагааны хэрэгжилтийг ерөнхий захирлын өмнө хүлээх үүрэгтэй ажиллана.

6.2 Хяналтын механизм

- Санхүүгийн хяналт
- Байгууллагын үйл ажиллагааны түвшний хяналт
- Удирдлагын зүгээс шийдвэр гаргах үйл явцад тавих хяналт
- Дотоод аудит хяналт шинжилгээ, үнэлгээ

Энэхүү механизм нь дээрээсээ доод шат руу чиглэсэн шууд хяналт байна. Үүнд:

- Ерөнхий захирлын дэргэдэх удирдлагын зөвлөл

- Албадын дарга нар
- Тасгийн эрхлэгч
- Чанарын менежерүүд

Хяналт нь салбарын алба, нэгжүүд холбогдох хууль тогтоомж, тушаал, шийдвэрүүдийн биелэлтийг хангаж байгаа байдал, жил, улирал, хэтийн төлөвлөгөөний биелэлтийг хангах, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг шалгуур үзүүлэлтийн дагуу хийж байгаа байдалд үнэлгээ өгч байр эзлүүлэн үр дүнг дүгнэнэ.

Алба, тасаг, нэгжийн ажилтан нарын ажлыг үр дүнгийн гэрээний дагуу шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ. Гүйцэтгэлийн хяналт шалгалт нь нээлттэй, ил тод, шударга байх зарчмыг баримтална.

6.3 Өмчлөлийн зорилт

Байгууллагын хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүхий л нөхцлийг бүрдүүлж эргэлт

ийн болон үндсэн хөрөнгөөр тасралтгүй хангаж, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг бүрдүүлж төсөвт зардлыг хямдруулж байгууллагын эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

Төвийн үндсэн хөрөнгө түүний дотор тавилга эд хогшил аппарат багаж хэрэгслэл нь 1986-онд анх ашиглалтанд орсноос хойш олон жил ашиглагдан, ерөнхийдөө муудаж, эмнэлэг үйлчилгээний өнөөгийн шаардлага хангахгүй хөрөнгө дийлэнхи хувийг эзэлж байгааг шинэчлэх.

Мөн төвийн барилгыг 1986 онд анх ашиглалтанд хүлээн авсан бөгөөд одоо хүртэл иж бүрэн их засвар хийгдэж байгаагүй. Сантехникийн шугам сүлжээ муудсан, их засвар хийх зайлшгүй шаардлагатай.

Эм, эмнэлгийн хэрэгсэл бэлтгэн нийлүүлэгч байгууллага болон төсвийн хөрөнгөөр нийлүүлэх бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах журмын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр байгууллагын бизнесийн хүрээг өөрчилж чанартай бүтээгдэхүүнийг зах зээлийн бөөний үнээр авах.

Үндсэн хөрөнгө:

2017 онд:	Орон барилга	19.906.688.928	мянган төгрөг
	Тээврийн хэрэгслэл	1.205.169.054	мянган төгрөг
	Тоног төхөөрөмж	8.766.694.913.82	мянган төгрөг
	Тавилга эд хогшил	1.082.254.473.47	мянган төгрөг
	Ном	7.842.697.31	мянган төгрөг
	Нийтийн эзэмшил	237.315.782	мянган төгрөг
	Бүгд	23.205.965.848	мянган төгрөг

6. 4 Хүний нөөцийн бодлого

Байгууллагын хэмжээнд баримтлах хүний нөөцийн бодлогыг ил тод зарчимд тулгуурлан ажилд шинээр авах, томилох, сургаж хөгжүүлэх ажил дүгнэх, урамшуулал олгох зэрэг журмыг байгууллагын дотоод дэг журам, хамтын гэрээнд тусган хэрэгжүүлнэ.

Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгож, удирдлагын шат дамжлагыг цөөрүүлэн, ажлын байрны тодорхойлолт, ажлын үр дүнг үнэлэх үнэлгээг

боловсронгуй болгоно. Эмч, эмнэлгийн ажиллагсдын мэргэжлийн онцлог, ажлын байрны нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр дүрэм журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ.

Байгууллагын хүний нөөцийн бодлогыг эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого, төвийн 2018-2022 оны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлын байрны тодорхойлолт, ажлын үнэлгээг боловсруулан, хүний нөөцийг зөв зохистой бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Долоо. Хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэл

ХӨСҮТ-ийн 2018-2022 оны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэл нь:

- Бодлогын өөрчлөлтийн улмаас төвийн бүтэц, тогтолцоо өөрчлөгдөх
- Халдварт өвчний гэнэтийн тахал, цар тахлын улмаас төвийн хэвийн үйл ажиллагаа хэт ачаалалд орж бүх төрлийн нөөц хомсдох
- Олон улсын санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаа зогсох
- Эдийн засгийн хямралаас шалтгаалсан төсөв мөнгөний хомсдол

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХЭТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ МАТРИЦ

Зорилго 1: Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх үйл ажиллагааны удирдлага төлөвлөлтийг боловсронгуй болгох зорилгын хүрээнд									
№	Байгууллагын стратеги	Хүрэх үр дүн	Байгууллагын стратегийн үйл ажиллагаа	Хугацаа / 2018-2022 он /					Хариуцах эзэн
				2018	2019	2020	2021	2022	
1	Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх үндэсний бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх ажил сайжирна	Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	+	+	+			Аймаг, нийслэлийн ЭМГ
